

# ДОТООДЫН

**ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО  
ХОНОГИЙН ТОЙМ**



2025.09.01

## Дотоодын зах зээлийн онцлох мэдээ

## ТОВЧ

- ТОП-20 индекс оны эхнээс 6.23% унажээ
- ТОП-20 индексийн дэмжлэгийн бүс 46,300
- Голомт банкны хувьцаа хамгийн идэвхтэй арилжаалагдлаа
- TSX:ERD хувьцаа 1.28 канад долларт хүрлээ
- Сүү ХК 6 төгрөгийн ногдол ашиг тараана

## МХБ-ийн индексийн өгөөж

Индекс	Долоо хоног	Сар	Жил
ТОП 20	-0.40%	-0.71%	25.47%
MSE A	-0.50%	-1.21%	20.27%
MSE B	0.04%	-0.21%	34.89%

2025/08/25 – 2025/08/29

## Идэвхтэй арилжаалагдсан үнэт цаас

Симбол	Үнийн дүн
GLMT	888,249,947.00
KHAN	518,205,368.00
ERDN	180,207,664.00
MFG	88,786,753.21
TTL	67,938,360.00

2025/08/25 – 2025/08/29

## Өндөр өсөлттэй үнэт цаас

Симбол	Хаалтын ханш	Өсөлт %
BODI	87.99	15.78%
ETR	117.31	15.00%
EER	4,312.00	14.99%
LEND	164.86	12.15%
HBO	35.00	6.06%

2025/08/25 – 2025/08/29

2025 он 09-р сарын 01

Зах зээлийн  
үнэлгээ тэрбум ₮

12,311

ТОП-20 индекс

48,393

MSE A

17,994

MSE B

14,464

## МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ДНБ өсөлт

5.6%

2025 - II улирал

Инфляц

8.1%

2025-07 сар

ГВУН(сая\$)

5,379.75

2025-07 сар

Бодлогын

хүү

12.0%

ЗГ-ын бондын

өгөөж

6.6%

USD/MNT

3,592.79

2025-08-31

## ЭДИЙН ЗАСГИЙН МЭДЭЭЛЭЛ

### ЭРДЭНЭ РЕСУРС ХК-ИЙН ХУВЬЦААНЫ НЭГТГЭЛТЭЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЭЛ



Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX:ERD; MSE:ERDN; OTCQB:ERFCF) нь 2025 оны 6-р сарын 25-нд болсон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар компанийн гаргасан зургаан (6) энгийн хувьцааг нэг (1) энгийн хувьцаанд нэгтгэх шийдвэрийг баталсан билээ.

Хувьцааны нэгтгэлийн хугацаа ба журам

- Хүчин төгөлдөр болох өдөр: 2025 оны 9-р сарын 2
- Монголын хөрөнгийн бирж: 2025 оны 8-р сарын 27-ноос эхлэн арилжаа түр хугацаанд зогсоно.
- Торонтогийн хөрөнгийн бирж: Арилжаа хэвийн үргэлжилнэ.

Хувьцааны тоо хэмжээ

- Нэгтгэлээс өмнө: 366,231,958 ширхэг энгийн хувьцаа
- Нэгтгэлийн дараа: ойролцоогоор 61,038,660 ширхэг энгийн хувьцаа  
(бутархай хувьцааг дээш бүхэлдүүлэхээс шалтгаалан бага зэрэг өөрчлөгдөж болно)

Нэгтгэлийн дараа бутархай хувьцаа гаргахгүй, харин хамгийн ойрын бүхэл тоонд дээш нь тоймлон тооцно. Торонтогийн хөрөнгийн бирж дээрх арилжаа тасалдахгүй, харин Монголын хөрөнгийн бирж дээр түр хугацаанд зогсоох шийдвэр гарсан.

### ММС-ИЙН FITCH 'B+' ҮНЭЛГЭЭГ ХАДГАЛЛАА

Fitch Ratings 2025 оны 8 дугаар сарын 25-нд Монголын нүүрсний үйлдвэрлэгч Mongolian Mining Corporation (ММС)-ийн урт хугацааны гадаад валютын зээлжих зэрэглэлийг "B+" түвшинд хадгалж, төлөвийг "тогтвортой" гэж үнэлжээ. Мөн 2030 онд төлөгдөх компанийн бондыг мөн "B+" үнэлгээгээр баталгаажуулсан байна.

Энэ үнэлгээний үндсэн шалтгаан нь ММС-ийн санхүүгийн үзүүлэлтүүд харьцангуй сайн, өрийн түвшин маш бага байгаа хэдий ч бизнесийн хэмжээ жижиг, бүтээгдэхүүн болон хэрэглэгчийн төвлөрөл өндөр, мөн Монголын уул уурхайн зохицуулалт тогтворгүйд тооцогдож байгаатай холбоотой юм. Тус компани 2025 онд нүүрсний үнэ буурснаас орлого, EBITDA буурна гэж Fitch тооцоолж байгаа бөгөөд ашигт ажиллагааны түвшин 2024 онд 47% байсан бол 2025 онд 36% болж буурах магадлалтай гэж үзжээ.

### СҮҮ ХК НЭГЖ ХУВЬЦААНД 6 ТӨГРӨГИЙН НОГДОЛ АШИГ ТАРААХААР БОЛЛОО

"Сүү" ХК нь Компанийн тухай хууль болон компанийн дүрмийн холбогдох заалтыг үндэслэн, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн 19 дүгээр тогтоолоор 2025 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас 2.06 тэрбум төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон тараахаар шийдвэрлэжээ.

Тус шийдвэрийн дагуу нэгж хувьцаанд 6 төгрөгийн ногдол ашиг олгох бөгөөд ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг 2025 оны 9 дүгээр сарын 26-нд гаргаж, ногдол ашгийг 2025 оны 12 дугаар сарын 31-нээс өмнө бүрэн тараах юм.

Санхүүгийн үзүүлэлтүүд

- 2025 оны 1-р хагаст компанийн борлуулалтын орлого 115 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 19.8%-иар өссөн байна.
- Харин цэвэр ашиг 6.89 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 43.4%-иар буурчээ.
- 2025 оны 8-р сарын 25-ны байдлаар тус компанийн хувьцааны Үнэ-Ашгийн харьцаа (P/E) 18.47 байгаа нь зах зээл дэх үнэлгээний түвшинг харуулж байна.

**Зах зээлийн мэдээлэл**

**ТОП-20 ИНДЕКС ОН ГАРСНААС ХОЙШ 6.23% УНАЛАА**

График 2. ТОП-20 индексийн ханшийн өөрчлөлт



ТОП-20 индекс 2025 он гарснаар 6.23 хувиар унаад байна. Компаниудын орлого эхний хагас жилд өссөн ч гэсэн цэвэр ашиг өнгөрсөн оны мөн үеэс буурсан үзүүлэлттэй байлаа. Ханш 46,300 түвшин рүү үргэлжлэн унах магадлал өндөр бөгөөд 46,300 хүчтэй дэмжлэгийн бүс болж байна. Энэ оны сүүлийн улиралд индекс хүчтэй өсөх магадлалай.

**TSX:ERD ХУВЬЦААНЫ ХАНШ 1.28 канад долларт хүрлээ**




## ДОТООДЫН ХУВЬЦААНД ХЭЗЭЭ ХӨРӨНГӨ ОРУУЛАХ ВЭ?

ТОП-20 индексийн хэлбэлзэл (2015-2025)

	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025	ДУНДАЖ
1 сар	-2.10%	-1.00%	5.40%	-4.20%	7.50%	0.90%	10.50%	1.90%	3.50%	7.00%	2.90%	2.90%
2 сар	-3.50%	-3.00%	-0.90%	-0.10%	-0.60%	-0.90%	29.20%	-4.60%	2.40%	5.50%	1.70%	2.30%
3 сар	-3.50%	-5.10%	4.60%	-1.00%	-2.60%	-4.00%	31.20%	-6.10%	0.50%	1.90%		1.60%
4 сар	-3.00%	-1.50%	2.50%	-4.60%	-3.70%	-8.70%	4.10%	-0.90%	-5.20%	-3.30%		-2.40%
5 сар	-2.40%	-1.20%	-1.60%	-2.00%	0.30%	-2.10%	1.20%	-6.70%	0.50%	-0.40%		-1.40%
6 сар	13.90%	5.20%	-1.60%	0.90%	-1.80%	-1.00%	-7.70%	-3.70%	-0.60%	0.80%		0.50%
7 сар	-2.60%	10.80%	8.20%	-1.00%	3.60%	2.00%	-1.10%	-0.80%	1.10%	9.80%		3.00%
8 сар	-6.70%	-1.80%	8.70%	-0.90%	-2.80%	1.60%	7.70%	4.60%	0.00%	3.50%		1.40%
9 сар	-0.40%	-7.40%	16.60%	3.50%	-3.20%	2.70%	27.50%	-1.50%	-5.40%	-1.30%		3.10%
10 сар	-0.60%	-2.70%	16.90%	2.10%	-3.60%	1.60%	-10.00%	-1.90%	0.60%	0.20%		0.30%
11 сар	-2.90%	-3.40%	9.30%	-2.00%	0.00%	0.50%	-2.40%	1.10%	4.60%	1.80%		0.70%
12 сар	-3.60%	7.00%	0.10%	0.10%	1.90%	3.30%	5.80%	5.40%	5.00%	2.00%		2.70%

ТОП-20 индексийн сарын дундаж хэлбэлзэл (2015-2025)



Монголын ТОП-20 индексийн дундаж хэлбэлзлээс харахад 1-3 сар, 7-9 сар, 12 саруудад өсөлт давамгайлдаг байна.

### Ямар стратеги баримтлах вэ?

- Ногдол ашиг хүртэхийг зорьж буй бол 1-3 сард хувьцаа худалдаж авах нь тохиромжтой.
- Хямд үнээр хувьцаа авах боломж хайж байгаа бол 4-5 сард зах зээлийн уналтыг ашиглах хэрэгтэй.
- 7-9 сард зах зээл өсөх магадлалтай тул эрт худалдан авч, өсөлтийг ашиглах боломжтой.
- Жилийн эцэст (12-р сар) дунд хугацааны өсөлт ажиглагдах хандлагатай тул урт хугацааны хөрөнгө оруулалтад тохиромжтой үе.